

ЭН АР СИ СИ компани Хэрэглэгчийн итгэлийн улирал тутмын судалгааг Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төвтэй хамтран 2022 оны 6-р сард амжилттай зохион байгууллаа. Судалгаанд Монгол Улсын 21 аймаг, нийслэл Улаанбаатар хотын 1000 орчим иргэд хамрагдаж, эдийн засгийн өнөөгийн төлөв, ойрын ирээдүйн хандлагын талаар мэдээлэл өгсөн байна.


## Хэрэглэгчийн итгэлийн индекс

Монгол Улсын хэрэглэгчдийн эдийн засагт итгэх итгэл 2022 оны 2-р улиралд өмнөх улирлын түвшинд байна. Хэрэглэгчийн итгэлийн индекс (ХИИ) 87.5 байгаа нь жилийн өмнөхөөс 13.7 пунктээр өндөр байна. 2-р улирлын үзүүлэлтүүдийг өмнөх улиралтай харьцуулан авч үзье. Бизнесийн нөхцөл болон хөдөлмөрийн зах

зээлийн өнөөгийн байдлын талаарх хэрэглэгчдийн үнэлэмжийг харуулдаг *Өнөөгийн байдлын индекс* энэ улиралд 72-оос 109.5 болж өссөн. Харин хэрэглэгчдийн бизнесийн нөхцөл, орлого болон хөдөлмөрийн зах зээлийн ойрын ирээдүйн хүлээлтийг харуулдаг *Ирээдүйн хүлээлтийн индекс* 92-оос 80.3 болж эрс буурчээ.

## Хэрэглэгчийн Итгэлийн Индекс (2018=100)

Хэрэглэгчийн итгэл өмнөх улирлын түвшинд байгаа ч, жилийн өмнөхөөс 13.7 пунктээр өссөн байна. Энэ улиралд өнөөгийн байдлын үнэлэмж өссөн ч, ирээдүйн хүлээлт буурчээ.



Тайлбар: ХИИ болон түүний бүрэлдэхүүн индексүүдийг улирлын нөлөөгөөр засварлаж, 2018 оны индекстэй харьцуулж тооцсон (Индекс 2018=100).

### **Эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдал**

Хэрэглэгчдийн эдийн засгийн өнөөгийн байдлын үнэлэмж эрс сайжирсан байна. Бизнесийн нөхцлийн талаарх үнэлэмж сайжирсан байна. 8.9 хувь нь бизнесийн нөхцөл “сайн” гэж хариулсан нь 4.8 пунктээр өндөр байна. 43.9 хувь нь бизнесийн нөхцөл “муу” гэж хариулсан бөгөөд энэ нь 20.4 пунктээр бага байна. Хэрэглэгчдийн хөдөлмөрийн зах зээлийн үнэлгээ сайжирсан. 23.8 хувь нь ажлын олдоц “элбэг” гэж хариулсан нь өмнөх улирлаас 1.4 пунктээр өндөр, 30.6 хувь нь ажил олоход “хэцүү” гэж хариулсан нь өмнөх улирлаас 12.5 пунктээр бага байна.

### **Эдийн засгийн ойрын ирээдүйн төлөв**

Хэрэглэгчдийн эдийн засгийн ойрын ирээдүйн талаарх хүлээлт тодорхойгүй байна. Хэрэглэгчдийн 17.3 хувь нь ойрын ирээдүйд бизнесийн нөхцөл “сайн” байна, 23.6 хувь нь бизнесийн нөхцөл “муу” байна үзэж байгаа нь өмнөх улирлын орчимд байна. 12.3 хувь нь ажлын олдоц сайжирна гэж үзсэн нь 4.8 пунктээр бага байгаа бол 22.7 хувь нь муудна гэж үзсэн нь 6.5 пунктээр өндөр байна. Хэрэглэгчдийн 18.0 хувь нь орлого өснө гэж үзсэн нь 0.8 пунктээр өндөр, 12.7 хувь нь орлого буурна гэж үзсэн нь 2.5 пунктээр өндөр байна.

### **ХИИ-д нөлөөлж буй хүчин зүйлс**

	2022.II	2022.I	2021.II	Улирлын өөрчлөлт	Жилийн өөрчлөлт
<b>Өнөөгийн байдал</b>					
<i>Бизнесийн нөхцөл</i>					
Сайн	8.9	4.1	2.7	4.8	-6.2
Хэвийн	44.3	30.8	30.7		
Муу	43.9	64.4	66.1	-20.4	-22.2
<i>Ажлын олдоц</i>					
Сайн	23.8	22.3	23.1	1.4	0.7
Хэвийн	45.1	32.9	30.9		
Муу	30.6	43.2	45.2	-12.5	-14.6
<b>Ойрын ирээдүй</b>					
<i>Бизнесийн нөхцөл</i>					
Сайн	17.3	17.0	19.6	0.3	-2.3
Хэвийн	55.3	54.9	46.0		
Муу	23.6	23.6	30.9	0	-7.4
<i>Ажлын олдоц</i>					
Сайн	12.3	17.1	14.4	-4.8	-2.2
Хэвийн	63.5	63.0	57.4		
Муу	22.7	16.3	26.8	6.5	-4.1
<i>Орлого</i>					
Сайн	18.0	17.2	20.9	0.8	-2.8
Хэвийн	67.1	71.4	59.3		
Муу	12.7	10.2	17.4	2.5	-4.8


## Хэрэглэгчийн итгэл ба эдийн засгийн өсөлт

Хэрэглэгчийн итгэлийн индексийг олон улс орнууд үнэлж мэдээлдэг бөгөөд тухайн орны эдийн засгийн төлөв байдлыг сайн харуулж чаддаг гэж үздэг. Монгол Улсад ч ХИИ-ийг улирлаар үнэлж эхэлснээс хойшхи динамикийг харвал эдийн засгийн өсөлттэй ойрхон хамаа-

ралтай байна. ХИИ-ийн индекс хэвийн буюу 100 ба түүнээс дээш утгатай улирлуудад эдийн засаг дунджаар 6.1 хувийн өсөлттэй байсан бол ХИИ 100-гаас бага утгатай улирлуудад эдийн засаг 2.6 хувийн өсөлттэй байна.

## Хэрэглэгчийн итгэл ба эдийн засгийн өсөлт

Хэрэглэгчийн итгэлийн индекс эдийн засгийн өсөлттэй ойрхон хамааралтай байна



Эх үүсвэр: YCSX-ны 1212.mn мэдээллийн сайт. Тайлбар: Эдийн засгийн өсөлтийн мэдээллийг YCSX-ны цахим хуудаснаас авсан.



2022 оны хоёрдугаар улиралд хэрэглэгчдийн эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдлын үнэлэмж өмнөх улирлаас өөдрөг байгаа ч, ойрын ирээдүйн хүлээлт нь өмнөх улирлаас арай гутранги байна. Өнөөгийн өндөр инфляц болон инфляцыг бууруулах зорилготой мөнгөний хатуу бодлого хэрэгжүүлж байгаа нь хэрэглэгчдийн ойрын ирээдүйн хүлээлтийг бууруулж байна.


## Инфляцын хүлээлт

Ирэх 6 сарын хугацаанд үнийн түвшин өснө гэсэн хүлээлттэй иргэдийн хувь 82, ирэх нэг жилийн хугацаанд үнийн түвшин өснө гэсэн хүлээлттэй иргэдийн хувь 78 байна. Хэрэглэгчид инфляцын түвшинг ирэх 6 сар болон нэг жилийн хугацаанд харгалзан 9.5 болон 11.4 хувь байна гэсэн хүлээлттэй байна. Хүлээгдэж буй инфляцын ойрын 6 сар болон жилийн дараах түвшингүүд өмнөх улиралтай харьцуулахад буурсан бөгөөд 2021 оны мөн үетэй харьцуулахад өөрчлөгдөөгүй байна.

Эндээс үзвэл иргэдийн дийлэнх нь үнийн түвшин өснө гэж үзэж байгаа ч, өсөлтийн хурд нь саарна гэсэн хүлээлттэй байна. Хөдөө амьдардаг хэрэглэгчид Улаанбаатар хотод амьдардаг хэрэглэгчидтэй харьцуулахад ойрын 6 сард үнийн түвшинг илүү өндөр өснө гэж хүлээж байна. Хотод 6 сарын хүлээгдэж буй инфляц 9.3 хувь байгаа бол хөдөө 9.8 хувь гэж гарлаа. Жилийн инфляцын хүлээлт хот болон хөдөөний хэрэглэгчдийн дунд ялгаагүй байна.

## Үнийн хүлээлт, ирэх нэг жилийн хугацаанд

Ирэх нэг жилийн хугацааны инфляцын хүлээлт 11.4 хувь байгаа нь өмнөх улирлаас 2 орчим пунктээр бага байна. Өмнөх оны мөн үетэй ойролцоо байна.



Эх үүсвэр: ҮСХ-ны 1212.mn мэдээллийн сайт

